



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Хүнсний материалын зарцуулалтын  
хэмжээ, хоолны орц нормыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5; Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4,5 дугаар хавсралт, даргын дэргэдэх зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь.

1.Тус төвийн гал тогоонд хийгдэх хоолны орц нормд тооцох орлуулах материалын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, гал тогоонд хийгдэх хоолны орц нормыг 2 дугаар хавсралтаар, гал тогоонд зарцуулагдах 1 хүний 7 хоногийн хүнсний хэрэгцээнд зарцуулах хүнсний материалын хэмжээг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Цаашид хоолны цэс өөрчлөгдөх тухай бүр хоолны орц, нормыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалыг үндэслэн боловсруулан батлуулж байхыг ахлах тогооч, нягтлан бодогч нарт даалгасугай.

3.Батлагдсан орц нормын дагуу хоол үйлдвэрлэлийн технологийн картыг 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн дотор боловсруулж мөрдөж ажиллахыг ахлах тогооч Б.Мөнхтогоод үүрэг болгосугай.

4.Батлагдсан орц нормын дагуу хүнсний материалын зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч Б.Энхдолгорт даалгасугай.

ДАРГА



ЦЭРЭНДУЛАМ

3180600-9

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын  
2020 оны 01 сарын 21 ны өдрийн 4/ дугаартай  
тушаалын 1 дүгээр хавсралт



Нийгмийн хамгааллын тусгай төвийн гал тогоонд хийгдэх хоолны орц нормд  
тооцох орлуулах материалын жагсаалт (1 хүний, г-аар)

нэр төрөл	Хоногт хэрэглэх хэмжээ (г)	орлуулах материалаар тооцсон (г)	7 хоногийн хүнсний хэрэгцээ (г)
Малын мах	120.00	190.00	1,330.00
Загас	30.00	-	-
Шувууны мах	40.00	-	-
Сүү (үнээний сүү, 3.2% тос)	160.00	340.00	2,380.00
Цагаан идээ (тараг)	180.00	-	-
Гурил	100.00	280.00	1,960.00
Гурилан бүтээгдэхүүн	180.00	-	-
Төрөл бүрийн будаа	50.00	90.00	630.00
Буурцагт ургамал	40.00	-	-
Төмс	120.00	200.00	1,400.00
Хүнсний ногоо	260.00	180.00	1,260.00
Жимс, жимсгэнэ	200.00	200.00	1,400.00
Өндөг	20.00	20.00	140.00
Ургамлын тос	23.00	23.00	161.00
Цөцгийн тос, 72% тослог	10.00	10.00	70.00
Сахар, чихрийн зүйл	33.00	33.00	231.00





Нийгмийн хамгааллын тусгай төвийн  
 даргын 2020 оны 07 сарын 24 ны өдрийн  
 дугаартай тушаалын 3 дугаар  
 хаасралт



Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, орлуулах материалын хэмжээг тооцсон  
 зарцуулах материалын хэмжээ

нэр төрөл	1 хүний 7 хоногийн хүнсний хэрэгцээ (г)	1 хүний 7 хоногийн Хүнсний материалын бохир жин (г)	1 хүний 7 хоногт зарцуулах хүнсний материалын хэмжээ (г)
Малын мах	1,330.00	1,773.33	1,770.00
Сүү (үнээний сүү, 3.2% тос)	2,380.00	2,380.00	1,820.00
Гурил	1,960.00	1,960.00	1,910.00
Төрөл бүрийн будаа	630.00	630.00	830.00
Төмс	1,400.00	1,794.87	1,800.00
Хүнсний ногоо	1,260.00	1,482.35	1,424.00
Жимс, жимсгэнэ	1,400.00	1,473.68	350.00
Өндөг	140.00	140.00	122.00
Ургамлын тос	161.00	161.00	153.00
Цецгийн тос, 72% тослог	70.00	70.00	80.00
Сахар, чихрийн зүйл	231.00	231.00	195.00
Бусад амтлагчууд /давс, хар перец, хоол амтлагч, кетчуп г.м/	134.00	134.00	134.00